

БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ УЛС:

Авлигатай тэмцэх үйл ажиллагаа

АГУУЛГА

1.ИТАЛИ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	2
Авлигын нөхцөл байдал:.....	2
Авлигатай тэмцэх байгууллага:.....	4
Хууль эрх зүйн орчин:	5
Шүгэл үлээгчийн хамгаалалт:.....	5
Улс төрийн намын санхүүжилт:	6
Хөрөнгө буцаан олгох:	6
Итали дахь өндөр түвшний авлигын зарим хэргүүд	6

1.ИТАЛИ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Авлигын нөхцөл байдал:

Итали Улсад авлигын бол ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай асуудлын нэг юм. Тус Улсад зохион байгуулалттай бүлэглэл /мафи/ оролцсон эдийн засгийн гэмт хэрэг болон өндөр түвшний буюу сонгууль болон улс төрийн намын санхүүжилттэй холбоотой авлигын хэрэг гарах явдал түгээмэл байдаг^{1 2}. Транспарэнси интернэшнл байгууллагын Авлигын төсөөллийн индексийн дүнгээр Итали Улс 2014 онд дэлхийн 175 улсаас 69 дүгээр байрт 43 оноотойгоор орсон байдаг.

Хүснэгт 1. Зарим үзүүлэлтийн харьцуулалт

	Итали Улс ³	Монгол Улс
Ерөнхий мэдээлэл		
Нийт хүн ам	60.5 сая	3.0 сая
Нэг хүнд ногдох ДНБ	35685 ам.доллар	4056 ам.доллар
Дундаж наслалт	81	67
Авлигын нөхцөл байдал		
ТИ Авлигын төсөөллийн индекс:		
- Оноо	43/100	39/100
- Эрэмбэ	69/175	80/175
Авлигатай тэмцэх байгууллага	Үндэсний авлигатай тэмцэх байгууллага	Авлигатай тэмцэх газар
Удирдлагын томилох	Дээд шүүх	УИХ
Байгуулагдсан он	2014	2007
НҮБ-ын Авлигын эсрэг конвенц	2003 онд нэгдсэн 2009 онд соёрхон баталсан	2005 онд нэгдэж, соёрхон баталсан
ЭЗХАХБ-ын Хээл хахуулийн эсрэг конвенц	2001 онд соёрхон баталсан	-

Авлигын талаарх судалгаа: Европын комиссоос зохион байгуулсан “Авлигын Евробарометр-2013” судалгаагаар Итали Улсаас судалгаанд оролцогчдын 97% нь (Европын холбоонд хоёр дахь өндөр дүн, Европын улсуудын дундаж 76) авлига өргөн тархсан гэж үзсэн бол 42% нь өдөр тутмын амьдралд авлигын нөлөөлж байна хэмээн хариулсан байна. Италичуудын 88% нь хээл хахууль өгөх, танил талаа ашиглах нь тодорхой төрийн үйлчилгээг авах хамгийн хялбар арга гэж үзжээ. Мөн судалгааны дүнгээр улс төрийн нам болон улс төрчид; лиценз, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа; тендер шалгаруулалтын албан тушаалтнууд авлигад өртөх хамгийн их эрсдэлтэй гэж үзсэн байна.

¹ <http://www.business-anti-corruption.com/country-profiles/europe-central-asia/italy/snapshot.aspx>

² <http://www.elexica.com/en/legal-topics/employment-and-benefits/24-whistleblowing-in-italy>


³ data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.CD

“Дэлхий нийтийн авлигын хэмжүүр-2013” судалгааны үр дүнгээр сүүлийн 12 сарын хугацаанд төрийн үйлчилгээ авсан иргэдийн 13% нь төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан байна⁴.

“Авлигын Евробарометр-2013”-ийн бизнес эрхлэгчдийн судалгаанд оролцогчдын 92% нь Итали дахь бизнесийн өрсөлдөөнд авлига нөлөө үзүүлдэг, 64% нь бизнест амжилт олох цорын ганц арга зам бол улс төрийн хүрээнийхэнтэй холбоотой байх хэмээн хариулжээ.

Дэлхийн өрсөлдөх чадварын индексийн 2013-14 оны тайланд дурдсанаар авлигаар төсвийн хөрөнгийг шамшигдуулах, хууль бус шийдвэр гаргуулах, улс төрчдийн ёс зүйгүй байдалд итгэл алдарсан байдал зэрэг нь Итали Улс дахь засаглалын хамгийн анхаарал татсан асуудлуудын нэг болсон байна. Төрийн худалдан авах ажиллагаа, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудлууд авлигын эрсдэл хамгийн өндөртэй байдаг бөгөөд эдгээрт оролцож байгаа компаниуд нь зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлтэй ихэнхдээ холбоотой байдаг байна.

100000 хүнд ногдох авлигын хэргийн тоо⁵




Source: ISTAT

Транспарэнси интернэшнл байгууллагын Дэлхий нийтийн авлигын хэмжүүр 2013 судалгааны дүнгээр Итали улсад хамгийн их авлигад автсан байгууллагаар Улс төрийн нам, парламентыг нэрлэсэн байна.

⁴ http://www.transparency.org/country/#ITA_PublicOpinion

⁵ <https://www.opendemocracy.net/can-europe-make-it/andrea-capussela-vito-intini/corruption-in-italy-resilient-equilibrium>



Авлигатай тэмцэх байгууллага: Итали Улсад өндөр түвшний авлигын хэрэг гарах явдал түгээмэл байдаг бөгөөд 2009 онд Төрийн захиргаа, инновацийн сайд Брунетта Ренато⁶-ийн шийдвэрээр Төрийн захиргааны байгууллагын шударга, ил тод байдалд үнэлгээ өгөх хороо буюу CiVIT⁷-ийг байгуулсан байна. Улмаар 2012 оны 11 дүгээр сард Авлигын эсрэг хуулийг баталсан бөгөөд уг хуулийн дагуу CiVIT-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн Төрийн худалдан авах ажиллагааны хяналтын байгууллага⁸-тай нэгтгэх шийдвэр гарсан бөгөөд 2014 онд Үндэсний авлигатай тэмцэх байгууллага⁹-ыг байгуулаад байна.

Үндэсний авлигатай тэмцэх байгууллагын чиг үүрэг нь Италийн төрийн захиргаан дахь авлигаас урьдчилан сэргийлэх, удирдлагын бүхий л хүрээнд ил тод байдлыг нэвтрүүлэх, төрийн худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавих, авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах зэрэг болно. Үндэсний авлигатай тэмцэх байгууллагын удирдлагыг Дээд шүүхээс томилдог бөгөөд байгууллагын бүтэц, орон тоог Авлигын эсрэг хуулиар зохицуулдаг.

Авлигын эсрэг хуульд заасны дагуу Үндэсний авлигатай тэмцэх байгууллагын чиг үүрэг нь:

- Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэхийн тулд төрийн албан хаагчдад мөрдлөг болох стандарт, дүрэм, журам, гарын авлагыг бэлтгэх
- Хууль бус арга замаар олж авсан хөрөнгийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох.

⁶ Renato Brunetta

⁷ Commissione per la valutazione, la trasparenza e l'integrità delle amministrazioni pubbliche

⁸ Autorità per la vigilanza sui contratti pubblici di lavori, servizi e forniture

⁹ Autorità Nazionale Anticorruzione

Хууль эрх зүйн орчин: Италийн Эрүүгийн хуульд бусдаас сүрдүүлж мөнгө авах, идэвхтэй, идэвхгүй хэлбэрийн хээл хахууль, гадаадын төрийн албан хаагчдын хээл хахууль, луйвар, мөнгө угаах хэргүүдийг гэмт хэрэгт тооцохоор зааж өгсөн.

- Хувийн хэвшил хоорондын хээл хахууль ("Арилжааны хээл хахууль¹⁰"): Хувийн хэвшил дэх хээл хахуулийн асуудлыг Италийн иргэний хуулиар зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, хувийн хэвшилд ажиллаж буй этгээд нь өөрийн удирдлага, аудитор, санхүүгийн тайланг хянах чиг үүрэг бүхий этгээд болон бусад аж ахуйн нэгжийн ажилтанд мөнгө болон бусад үнэ бүхий зүйлсийг өгөх, эсхүл амалсан бол Иргэний хуулийн дагуу хариуцлага хүлээнэ. Уг хэрэгт компани нь буруутай бол 200-400 нэгж¹¹-ийн торгууль төлөх ёстой байдаг. Мөн өмнө нь энэ төрлийн хэрэгт холбогдож байсан компани дахин холбогдвол шийтгэлийн хэмжээ 2 дахин нэмэгдэж 800 нэгж хүрэх боломжтой.
- Нийтийн албан тушаалтан албан тушаалын байдлаа урвуулан ашиглах: Нийтийн албан тушаалтан албан тушаалтан болон нийтийн албаны зарим чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээд албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдад мөнгө болон бусад үнэ бүхий зүйлсийг өгсөн, амласан бол Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
- Аж ахуйн нэгж байгууллагын албан тушаалтан албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, нийтийн албан тушаалтныг албан тушаалын байдлаа урвуулан ашиглахад хүргэсэн бол тухайн аж ахуйн нэгжид хариуцлага хүлээлгэх буюу 300-800 нэгж (1600000 евро хүртэл) торгууль ногдуулна. Мөн нэг хүртэл жилийн хугацаанд тухайн компанийн үйл ажиллагааг нь хориглох, эсхүл төрийн байгууллагатай холбоотой үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг шийтгэл ногдуулдаг байна.
- Худалдан авах ажиллагааны "Цагаан жагсаалт": Нутгийн захиргааны байгууллага бүр худалдан авах ажиллагаанд ашиглах зорилгоор нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдийн "цагаан жагсаалт"-тай байх ёстой аж.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэмд төрийн албан хаагч бэлэг авах, сонирхлын зөрчил болон ил тод байхтай холбоотой зохицуулалтыг тусгаж өгсөн байдаг.
- Ерөнхий сайдын захирамж /Decree No. 33 (14 March 2013)/-ын дагуу төв болон бүс, орон нутгийн төрийн байгууллагад ажиллаж буй сонгогдсон, томилогдсон албан тушаалтнууд хөрөнгө, орлогоо мэдүүлэг ёстой.
- Итали Улс нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Хээл хахуулийн эсрэг конвенц, Европын холбооны Авлигын эсрэг иргэн, эрүүгийн хуулийн конвенц тус тус нэгдэн орсон улс юм.

Шүгэл үлээгчийн хамгаалалт: Авлигын эсрэг хуулийн дагуу төрийн байгууллага дахь авлигын асуудлаар мэдээлж байгаа шүгэл үлээгчийг хамгаалсан байдаг. Гэхдээ төрийн албан хаагчдын хувьд хязгаарлагдмал зохицуулалттай байдаг. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч шүгэл үлээхээр бол зөвхөн дээд албан тушаалтан болон Аудитын шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлд л мэдээлэх эрхтэй байдаг ба энэ нь

¹⁰ Commercial Bribery

¹¹ Энд дурьдсан нэгжийн хэмжээ нь тухайн компанийн орлого, үйл ажиллагааны хэмжээнд үндэслэн Еврогоор тодорхойлогдох бөгөөд ойролцоогоор нэг нэгж нь 600000 хүртэл евро байх боломжтой.

шүгэл үлээгчийн мэдээлэх сувгийг хязгаарлаж өгсөн, шүүмжлэлтэй байдаг байна. Харин хувийн хэвшил дэх шүгэл үлээгчийг хамгаалах талаар эрх зүйн зохицуулалтгүй.

Улс төрийн намын санхүүжилт: Аж ахуйн нэгжээс улс төрийн нам болон сонгуульд нэр дэвшигч нарт хандив өгөх үйл ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтгүй. Мөн сонгуулийн зардалд ч хязгаар байдаггүй. Зөвхөн 50000 еврогоос дээш хэмжээний хандив өгсөн хандивлагчийг олон нийтэд ил болгох ёстой байдаг ч уг зохицуулалт хэрэгждэггүй.

Улс төрийн нам болон сонгуулийн компани ажлын зарлагын дүнг мэдээлэх явдал хангалттай бус байдаг. Олон нийт улс төрийн намуудын санхүүгийн тайлантай танилцах боломж байдаггүй, мөн улс төрчдийн холбогдсон авлигын хэргүүд гарч байгаа нь намын системд итгэх олон нийтийн итгэлийг бууруулах хүчин зүйл болдог. Тухайлбал, ТИ байгууллагын Дэлхий нийтийн авлигын хэмжүүр судалгааны дүнгээр авлигад хамгийн их автсан байгууллагаар улс төрийн намыг нэрлэсэн байдаг.

Хөрөнгө буцаан олгох: Италийн Аудиторуудын шүүх¹²-ээс тооцсоноор Итали Улсад авлигын улмаас жил бүр 60 тэрбум евротой тэнцэх хохирол үүсч байгаа аж. Гэхдээ 2010 оны байдлаар, шүүхийн шийдвэрээр зөвхөн 293 сая еврогийн хөрөнгийг буцаан олгосон дүнтэй байна. Энэхүү зөрүүтэй байдалд нөлөөлж буй нэг хүчин зүйл нь хууль сахиулах үйл ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой юм. Жишээлбэл, 2005-2010 оны хооронд шалгагдсан эрүүгийн 10 хэрэг тутмын 1 нь шийдвэрлэгдэхээсээ өмнө хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан байна.

Итали дахь өндөр түвшний авлигын зарим хэргүүд¹³

1992 – Өндөр түвшний авлигыг илчлэн хэд хэдэн томоохон мөрдөн шалгах, баривчлах ажиллагаа явуулав. Мөн Мафийн эсрэг тэргүүн зэргийн прокурор Жиованни Фалкон¹⁴ болон түүний эхнэр, 3 бие хамгаалагч нар машинд нь тавьсан тэсрэх бөмбөгийн улмаас амиа алдав.

1993 – Хээл хахуулийн хэргийн улмаас Беттино Кракси¹⁵ Социалист намын даргын албан тушаалаасаа огцров. Үүний дараа тэрээр эх орноосоо оргон гарсан бөгөөд шүүхээс түүнийг эчнээгээр хорих шийдвэр гаргаад байсан ч, 2000 онд Тунис Улсад нас барав.

1994 – Эрх чөлөө эвсэл гуравдугаар сард парламентын сонгуульд ялав. Уг эвсэлд Сильвио Берлускони¹⁶-гийн “Forza Italia” нам болон “the Northern League and the neo-Fascist National” эвсэл багтаж байсан бөгөөд авлигын томоохон хэргүүдийн асуудал, мөн тэтгэврийн шинэчлэлийн улмаас тухайн онц эцэст эвсэл тарав.

2002 – Үндэсний мөнгөн тэмдэгт лирийг еврогоор солив. Гадаад харилцааны сайд Ренато Ружеро¹⁷ еврод шилжсэн асуудлаас болж огцров.

¹² Italy's Court of Auditors

¹³ <http://www.bbc.com/news/world-europe-17435616>

¹⁴ Giovanni Falcone

¹⁵ Bettino Craxi

¹⁶ Silvio Berlusconi

¹⁷ Renato Ruggiero

2003 – Төрийн 5 өндөр албан тушаалтныг гэмт хэрэгт холбон мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг хориглосон хуулийг парламентаас гаргасны дараа Берлусконийгийн авлигын хэргийн шүүх хурлыг зогсоов.

2003 – Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Parmalat” компани дахь олон тэрбум евротой тэнцэх луйврын хэрэг ил болов. Тус компани дампуурлаа зарлав.

2004 – Дээд шүүхээс Берлускони болон бусад төрийн өндөр албан тушаалтнуудыг гэмт хэрэгт холбон шалгахгүй байх эрх ямба олгов. Шүүхээс Берлусконийг хэргээс цагаатгав.

2009 – Дээд шүүхээс Берлусконийг албан үүргээ хэрэгжүүлж байхад гэмт хэрэгт холбохгүй байх эрх ямба олгосон хуулиа хүчингүй болгов.

2011 – Милан хотын шүүхээс Берлусконийг насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орсон, албан тушаалаа урвуулан ашигласан зэрэг хэрэгт буруутгав.

2013- Утас чагнасан хэргээр Берлусконгийг шүүхээс 1 жилийн ял ногдуулав. Давж заалдах шатны шүүхээс түүний хэргийг хэрэгсэхгүй болгов.

2013-Татвараас зайлсхийсэн хэргээр 2012 оны 10 дугаар сард шүүхээс шоронд хоригдох, төрийн албыг 2 жил хаших эрхээ хасуулах ял аваад байсан Берлусконгийн хэргийг Дээд шүүх хэлэлцэн олон нийтийн ажил хийх ял болгов.

2013 –Татвараас зайлсхийсэн хэргийнх нь улсаас Берлусконгийг Сенатын танхимаас хөөв.

2014- Берлусконийгийн Насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орсон гэх хэргийг хяналтын шатны шүүхээс хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргав.

2. ИТАЛИЙН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР СҮҮЛИЙН 2 ЖИЛД ГАРСАН ЗАРИМ МЭДЭЭ

1. Цагаачдын төвийг тойрсон авлигын хэрэг Италид дэгдэв¹⁸ (2015.06.04)

Ром. Мягмар гарагт 44 хүнийг баривчилсан талаар Италийн цагдаагийн газраас мэдээлэв. Цагаачдыг хүлээн авах төвийг ажиллуулах менежментийн гэрээг будлиулсан хэрэгт сэжиглэгдэж байгаа улс төрчид, төрийн албан тушаалтууд, бизнес эрхлэгчдийн авлигын сүлжээнд хамааралтай гэж үзэж тэднийг баривчилсан байна.

Эдгээр баривчилгаа нь өнгөрсөн жил Ром хотын засаг захиргаанд үүрлэсэн өргөн хэмжээний авлигын тогтолцоог илрүүлсний дараа болж байна. Мафийн нийслэл¹⁹ гэж нэрлэгдсэн тэрхүү хэрэг явдал нь хотын захиргаанаас хувийн хэвшлийхэнтэй байгуулсан олон тооны гэрээ хэлцлүүдийг шалгах хүсэлтийг хотын зөвлөлийн зүгээс үндэсний авлигатай тэмцэх байгууллагад тавихад хүргэсэн юм.

Саяны баривчилгаанууд нь мафийн нийслэл гэж нэрлэгдсэн хэргийг лавшруулан шалгасны үр дүн ажээ. Одоогоор 44 хүн баривчлагдаад байгаа ч дахин

¹⁸ <http://uk.reuters.com/article/2015/06/04/uk-italy-corruption-idUKKBN0OK0NL20150604>

¹⁹ Mafia Capital

21 хүнийг Италийн төв хэсгийн Ром, Л Аквила²⁰, Сицил²¹ дэх Катаниа²², Енна²³ хотуудаас баривчлах зөвшөөрлийг баталсан байна.

Энэхүү мөрдөн байцаалтын үр дүнд цагаачдын хүлээн авах төвийг ажиллуулах менежментийн гэрээг байгуулах этгээдийг шалгаруулахтай холбоотой хууль бус зохион байгуулалттай үйл ажиллагааг илрүүлсэн бөгөөд Газрын дундад тэнгист үүсээд байгаа цагаачдын хямралтай холбоотойгоор цагаачдыг хүлээн авах төвийг ажиллуулах нь асар их ашигтай бизнес болоод байгаа юм.

“Мафийн нийслэл” гэж нэрлэгдсэн хэрэгт холбогдсон хамгийн өндөр албан тушаалтан бол Ром хотын захирагч асан Жианни Алеманно бөгөөд тэрээр өнгөрсөн жил барууны чиглэлийн Италийн Ахан дүүс нам дахь албан тушаалаасаа огцорч байсан юм.

2. Итали Улсад төрийн мэдлийн компаниудын захирлуудын зөвлөлийг цэвэрлэхийг хүсч байна²⁴ (2014.03.28)

Итали. Тус улсын Засгийн газар төрийн мэдлийн компаниудын захирлуудын зөвлөлийн бүрэлдэхүүнээс санхүүгийн гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийг зайлуулж, ингэснээр авлигатай тэмцэх, компанийн үйл ажиллагааны шударга байдлыг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Сангийн Сайдаас төрийн мэдлийн компаниудад захидал илгээжээ. Уг захидалд хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр компанийн удирдлагын асуудалд илүү хатуу байр суурьтай байж, тавигдах шаардлагыг чангатгахыг хүсчээ.

Захидалд дурдахдаа албан тушаалын болон санхүүгийн гэмт хэрэг үйлдсэнд сэжиглэгдсэн л бол шүүхээс гэм бурууг тогтоохыг хүлээлгүйгээр төрийн мэдлийн компаниудын удирдлагаас албан тушаалтнуудыг зайлуулж байх ёстой гэжээ.

Италийн шүүх тогтолцоо нь маш төвөгтэй, удаан үргэлжилдэг учраас эцсийн шийдвэр гарах хүртэл арваас дээш жил болох тохиолдол ч бий.

3. Боссууд Италийн авлигын хэмжээг 300 тэрбум еврод хүргэжээ (2014.12.17)²⁵.

Төрийн болон хувийн хэвшил дэх ужгирсан авлига, шан харамжийг арилгах үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлж чадсан бол Италийн эдийн засаг одоогийн байгаа түвшнээс тав дахин том байх байсан гэдгийг Конфиндустриа²⁶ байгууллагын ажилтнууд хэлж байна.

1992 онд илрүүлсэн өргөн хэмжээтэй авлигын сүлжээний үр дагаварыг арилгах талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч чадаагүйн улмаас эдийн засагт учирсан хохирлын хэмжээг Конфиндустриа байгууллага өөрийн “Авлига: Хөгжил дэвшил дэх үхлийн дарамт” нэртэй тайланд тооцоолон гаргахыг оролдсон байна. Тэрхүү авлигын сүлжээнд Италийн хууль тогтоогчдын 50 хувь нь орооцолдсон байсан бөгөөд нэр хүнд бүхий улс төрчид, бизнес эрхлэгчдийг баривчлан шүүн тасалсан юм.

²⁰ L'Aquila

²¹ Sicily

²² Catania

²³ Enna

²⁴ <http://www.trust.org/item/20140328155746-syn6j/>

²⁵ <http://www.thelocal.it/20141217/bosses-put-italys-corruption-bill-at-300-billion>

²⁶ Confindustria

4. Венец хот авлигын давалгаанд живж байна (2014.7.19)²⁷.

1966 оны 11 дүгээр сард Венец²⁸ хот өөрийн түүхэн дэх хамгийн их хэмжээний үерт автагдаж бараг бүхэлдээ живж алга болох шахсан юм. Үүний дараа хотын иргэд ийм үер дахин болохоос сэргийлж ямар нэг арга хэмжээ авах шаардлагатай гэдэгт санал нийлж байлаа. Энэ бол Ла Серениссима²⁹-гийн хувьд амьдрал эсвэл үхлийн сонголт байв.

Гарах гарцыг олоход 20 жил шаардагдав. Эсвэл бүгд тэгж л бодож байлаа.

1980-аад оны эхээр Италийн хамгийн том барилгын компаниудын нэгдэл болох Консорзио Венециа Нуова (КВН)³⁰ буюу “Шинэ Венец” консорциум өөрийн төлөвлөгөөгөө санал болгов. Ром дахь Италийн Засгийн газраас санхүүжүүлсэн Мосе³¹ нэртэй энэ санал нь өөрийн шийдлээрээ дэлхийд анхны үерийн хаалтын систем³² болох байв.

Дараагийн жилүүдэд Мосе төлөвлөгөө 7.6 тэрбум³³ долларын өртөг бүхий төсөл болж урагшлав. Цагтаа аугаа хүчирхэг байсан ФИАТ нэгтгэл³⁴-ийн гишүүн болох Импрегило корпораци³⁵ зэрэг хувь нийлүүлэгчидтэй энэ төсөл амжилттай хэрэгжих мэт санагдаж байв. Гэвч Венец хотын захирагч Гиоргио Орсо³⁶ өнгөрсөн сард баривчлагдсанаар бүх зүйл өөрчлөгдөв. Тэрээр улс төрийн компани ажилдаа зориулж СВН-ээс мөнгө авсан хэрэгт буруутгагдаж байна. Түүнийг баривчлагдсан өдөр Италийн цагдаагийн газар өөр 35 хүнийг авлига, хээл хахууль, мөнгө угаасан хэргээр мөн баривчлан саатуулжээ. Тэднээс гадна 100 эсвэл түүнээс олон хүнийг мөрдөн шалгаж байна.

16 дугаар зууны үед оршин тогтнож байсан Венецийн Бүгд Найрамдах Улс³⁷-аас эхлэлтэй зуун зууны түүхээрээ бахархдаг Венецчүүдийн хувьд энэ бүх хэрэг явдал ичгүүр, гутамшгийг авчирч байна.

5. Италийн Венец хотын даргыг авлигын хэргээр саатуулаад байна (2014.06.30)³⁸.

Өнгөрсөн лхагва гарагт Венец хотын дарга болон бусад 30 гаруй хүнийг тус хотын үерийн хамгаалалтын олон сая долларын төсөлтэй холбоотой авлигын хэрэгт холбогдуулан Италийн холбогдох байгууллага саатуулаад байна.

²⁷ <http://www.newsweek.com/venice-sinking-under-tidal-wave-corruption-259878>

²⁸ Venice

²⁹ La Serenissima

³⁰ Consorzio Venezia Nuova (CVN)

³¹ Mose (Experimental Electromechanical Module)

³² the first system of submergible floodgates

³³ billion

³⁴ FIAT group

³⁵ Impregilo corporation

³⁶ Giorgio Orsoni

³⁷ Venetian Republic

³⁸ http://www.nytimes.com/2014/06/05/world/europe/venice-mayor-is-arrested-on-corruption-charges.html?_r=1

Венец хотын дарга Жоржио Орсонийг тус хотын үерийн хамгаалалт барих төслөөс урвуулан ашигласан хэрэгт буруутгаад байгаа бөгөөд түүнийг гэрийн хорионд оруулсан байгаа ажээ. Мөрдөн байцаагчид мөн парламентийн доод танхимын нэгэн гишүүн болон Венецийн бүсээс сонгогдсон хэд хэдэн сонгуульт албан тушаалтнуудыг саатуулсан байна.

Итали улсад авлигын гэмт хэрэг ховор үзэгдэл биш юм. Прокурорууд хотын даргыг төсвийн хөрөнгийг “улс төрийн зорилгоор ашигласан” хэрэгт буруутгаад байгаа бөгөөд мөрдөн байцаагчид үерийн хамгаалалтын төслийн гэрээг байгуулахын тулд улс төрчдөд 25 сая орчим евро буюу 34 сая долларыг хээл хахуульд өгсөн эсэхийг шалгаж байгаа юм.

Энэ хэрэг дээр ажиллаж байгаа прокуроруудын нэг болох Карло Нордио /Carlo Nordio/ телевизэд ярилцлага өгөхдөө “орон нутгийн бизнесменүүд болон улс төрчид хамтран хээл хахууль өгөх, хөрөнгө завших зорилгоор Швейцари, Сан Марино зэрэг улсуудаар дамжуулан мөнгө угаах нарийн зохион байгуулалттай систем бий болгосон байсан” гэжээ. Түүнээ хэлснээр улс төрчдөд хээл хахууль өгөхийн тулд бизнесменүүд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хуурамч зөвлөхийн гэрээ байгуулах, ханшийг зохиомлоор унаган төлбөр хийх зэрэг хууль бус үйлдэл гаргасан ажээ.

Венец хотын үерийн хамгаалалтын энэхүү төлөвлөгөө сүүлийн хэдэн жилийн турш маргаан, санал зөрөлдөөн ихтэй асуудлын нэг байсаар ирсэн юм. Усны түвшин нэмэгдэхээс хамгаалах зорилго бүхий далд далангийн системийн энэ төсөл 5-6 жилийн өмнө маргаантайгаар эхэлсэн юм.

Өнгөрсөн оны 7 дугаар сард Италийн цагдаа нар тус төсөлтэй холбоотой авлигын хэргээр Италийн Аж үйлдвэрийн консорциумын ерөнхийлөгчийг баривчилж байсан юм. Венец хотын даргыг баривчлахаас гадна албаныхан экс ерөнхий сайд Силвио Берлусконигийн тэргүүлдэг “Forza Italia” намын гишүүн, соёлын өв хариуцсан сайд асан Гианкарло Галан /Giancarlo Galan/-ийг баривчлахыг хичээж байгаа аж. Учир нь Гианкарло Галан бол олон жилийн турш Венецийн захиргааны асуудлыг хянаж байснаас гадна одоогоор парламентийн гишүүн бөгөөд түүнийг шалгахад гишүүний халдашгүй байдал саад болсоор байгаа юм.

Өөр нэгэн эрхэм буюу Венец хотын даргаар өмнө нь ажиллаж байсан Массимо Кассиари-“ Sky Tg24” агентлагт өгсөн ярилцлагадаа “энэ байдлаар Италид нийтийг хамарсан томоохон ажил эхлүүлэх бүрт л авлига, хээл хахуулийг бий болгож байна. Бүх зүйл цөөн хүн эсвэл цөөн аж ахуйн нэгжийн гарт орж, бөөгнөрсөн тул тэд юу хүссэнээ хийж байна” гэсэн юм.

Итали улс нь ТИ байгууллагын Авлигын төсөөллийн индексийн судалгаагаар өнгөрсөн онд 177 улс орноос 69 дүгээр байрт эрэмбэлэгдэж байсан юм.

Эх сурвалж:

6. Сильвио Берлускони: Баривчлагдвал Италид хувьсгал гарах болно (2013.12.12)³⁹.

Өнгөрсөн сар Сенатаас хөөгдөн гишүүнийхээ эрх ямбыг алдаад байгаа Италийн Ерөнхий сайд асан Сильвио Берлускони /Silvio Berlusconi/ өнгөрөгч пүрэв гарагт хэлэхдээ “хэрвээ түүнийг баривчлан, шоронд хоривол, хувьсгал гарах болно” гэжээ.

Хэвлэлийн магнат, 77 настай Сильвио Берлускони татвараас зайлсхийсэн хэрэгт буруутган 4 жилийн хугацаанд шоронд хорих шүүхийн шийдвэр гарсны дараагаар түүнийг Сенаторын суудлаас нь буулгасан юм. Энэ нь түүнийг сенатороор ажиллах хугацааг нь нэг жилээр багасгаж байгаа гэсэн үг болж байна.

Одоогийн байдлаар, түүнийг эсрэг эрүү үүсгээд улс төрийн хээл хахуулийн болон бусад хэргүүдэд сенаторын албан тушаалын халдашгүй байдлын хамгаалалтгүйгээр Сильвио Берлускони илүү эмзэг болоод байгаа юм.

Мөн насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орсон, албан тушаалаа урвуулан ашигласан хэргүүдэд түүнийг буруутай болохыг тогтоогоод байгаа ч уг шийдвэрийн тэрээр давж заалдаад байгаа юм.

Францын “Европ 1” радиод өгсөн ярилцлагын үеэр баривчлагдахаас айж байгаа эсэхийг нь асуухад тэрээр “Үгүй. Тэднийг чадна гэдэгт би итгэхгүй байна. Хэрэв тэгвэл Итали Улсад хувьсгал гарах болно” гэж хариулсан юм.

Итали Улс даяар тариачид, тээврийн жолооч нарын өрнүүлээд байгаа эсэргүүцлийн жагсаал хийсэн энэ долоо хоногийн үеэр уг тайлбарыг хийсэн юм.

"Pitchfork" нэртэй уг эсэргүүцлийн жагсаал нь Итали орныг 10 жилийн өмнөхөөс жижиг эдийн засагтай улс болсон, залуучуудын ажилгүйдлийн түвшин 40 хувьд хүрсэн зэрэг тус улсын эдийн засгийн тулгамдсан асуудлуудын эсрэг улс төрчид дорвитой алхам хийхгүй байгаад нь бухимдлаа илэрхийлээд байгаа юм.

Италийн улс төрийг 20-иод жил тэргүүлсэн, Сенатийн танхимаас гэмт хэрэгт холбогдон хөөгдсөнийхөө дараа ч тэрбумтан, улс төрч Сильвио Берлускони Ерөнхий сайд Энрико Летта /Enrico Letta/-ийн Засгийн газрыг тогтворгүй байдалд оруулах бүхий л нөөц бололцоогоо ашиглах нь үүгээр илэрхий болоод байна.

---oOo---

³⁹ <http://www.trust.org/item/20131212090107-fj9ns/?source=hptop>